МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 11 сарын 06 өдөр Дугаар 48 Улаанбаатар хот

"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулах тухай

Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт, 61.4, 61.9 дэх хэсэг, 73 дугаар зүйлийн 73.1, 73.3, 73.5, 73.6, 73.8 дахь хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3 дахь заалт, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 2026 оны 412 дугаар тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 377 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам", "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн 4 дүгээр зүйлийн 4.3.5 дахь заалт, "Санал хүргүүлэх тухай" Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2026 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн ХЭГ/3650 тоот албан бичиг, "Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам"-ын 2.6.1, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулсугай.

2. Эчнээ санал хураалтын саналын хуудсыг хувьцаа эзэмшигчдэд хүргүүлэх өдрийг 2026 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөр, хувьцаа эзэмшигчдээс саналын хуудсыг хүлээж авах сүүлийн өдрийг 2026 оны 12 дугаар сарын 28-ны өдрөөр тус тус тогтоосугай.

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулах тухай мэдэгдлийг 2026 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон "Монголын хөрөнгийн бирж" ХК-д тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Ж.Золбаярт үүрэг болгосугай.

4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулах тухай зарыг 2026 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр болон 11 дүгээр сарын 27-ны өдрүүдэд "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд мэдээлэхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анарт даалгасугай.

5. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудалд санал өгөх саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөр тогтоосугай.

1529010144

6. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлын жагсаалт, шийдвэрийн төсөл, саналын хуудас зэрэг хуралтай холбоотой бусад баримт бичгийг 2026 оны 11 дүгээр сарын 16-ны өдөр үнэт цаасны брокер дилерийн компаниудад хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлэхийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анарт даалгасугай.

7. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудлын жагсаалтыг Нэгдүгээр хавсралтаар, Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг эчнээ санал хураалтаар явуулах тухай зарыг Хоёрдугаар хавсралтаар, Эчнээ санал хураалтаар шийдвэрлэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг Гуравдугаар хавсралтаар, Эчнээ санал хураалтын саналын хуудасны загварыг Дөрөвдүгээр хавсралтаар, Эчнээ санал хураалтыг зохион байгуулах комиссыг Тавдугаар хавсралтаар, Эчнээ санал хураалтын тооллогын комиссыг Зургаадугаар хавсралтаар тус тус баталсугай.

8. Эчнээ санал хураалтыг зохион байгуулахад шаардлагатай технологийн бэлэн байдал, дэд бүтцийг хангаж ажиллахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анарт даалгасугай.

9. Хувьцаа эзэмшигчдийг холбогдох материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлэх, шаардлагатай мэдээллээр хангаж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг зохион байгуулах комисс (Б.Анар)-т даалгасугай.

10. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Ш.Бат-Эрдэнийг томилсугай.

11. Эчнээ санал хураалтаар шийдвэрлэсэн асуудал болон шаардлагатай бусад материалыг Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон холбогдох бусад журамд заасан хугацаанд Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлэхийг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Ж.Золбаярт даалгасугай.

12. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн Нарийн бичгийн дарга Ж.Золбаярт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ш.БАТ-ЭРДЭНЭ

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 48 дугаар
тогтоолын Нэгдүгээр хавсралт

ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР ШИЙДВЭРЛЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай;
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, нөхөн сонгох тухай.

--o0o--

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 48 дугаар
тогтоолын Хөёрдугаар хавсралт

“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫГ ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР ЯВУУЛАХ ТУХАЙ

“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 48 дугаар тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлаж байна.

Компанийн оноосон нэр: “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1 дүгээр хороо, Д.Сүхбаатарын талбай 3
Санал авч эхлэх хугацаа: 2026 оны 11 дүгээр сарын 16-ны өдрийн 09:00 цаг
Санал хүлээн авах сүүлчийн хугацаа: 2026 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 16:00 цаг
Хурал болох хэлбэр: эчнээ санал хураалтаар
Саналд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдөр

Хэлэлцэх асуудал:
1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай
2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, нөхөн сонгох тухай

Хувьцаа эзэмшигчдийн танилцах баримт бичгийн жагсаалт:
1. Эчнээ санал хураалтын саналын хуудас
2. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн дүрэмд оруулах өөрчлөлтийн төсөл
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн товч танилцуулга;
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийн төсөл
5. Шаардлагатай бусад материал

Хувьцаа эзэмшигч Та 2026 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн ажлын өдрүүдэд 09:00 - 17:00 цагийн хооронд өөрт тохиромжтой дараах газруудын аль нэгт эсхүл (www.mse.mn) цахим хуудсаар дамжуулан хурлын материалтай танилцах боломжтой.

- өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани;
- “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн байр Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Д.Сүхбаатарын талбай-3;
- Хурал зохион байгуулах комиссын утас: 11-313747, цахим шуудан (shareholders@mse.mn)

Хувьцаа эзэмшигч Та дээр дурдсан хугацаанд санал өгөх боломжтой бөгөөд саналын хуудсыг бөглөн өөрийн үйлчлүүлдэг брокер, дилерийн компаниар дамжуулан эсвэл “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн байранд биеэр ирж эсхүл цахим хэлбэрээр “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн цахим хуудас (www.mse.mn)-аар саналаа өгөх боломжтой ба санал авах сүүлчийн хугацаа 2026 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 16:00 цаг байна.

--o0o--

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 48 дугаар
тогтоолын 1 дүгээр хавсралт

ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТААР ШИЙДВЭРЛЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Эчнээ санал хуралтын саналын хуудас;
2. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн дүрэмд оруулах өөрчлөлтийн төсөл;
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшигчдийн товч танилцуулга;
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийн төсөл;
5. Шаардлагатай бусад материал.

--o0o--

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 48 дугаар
тогтоолын Дөрөвдүгээр хавсралт

ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТЫН САНАЛЫН ХУУДАС

Компанийн оноосон нэр: “МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК

Хувьцаа эзэмшигчийн овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр:

_____

Хувьцаа эзэмшигчийн дансны дугаар: | | | | | | | | | | |

Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар: | | | | | | | | | | |

Эзэмшиж буй хувьцааны төрөл: ___*энгийн*___

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү саналын хуудсаар 2026 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс 2026 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 16:00 цаг хүртэлх хугацаанд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн цахим хуудас /www.mse.mn/, өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компанид хандах болон Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Д.Сүхбаатарын талбай-3 хаягт байрлах “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн байранд биеэр ирж санал өгнө.

Саналын хуудсыг хүлээж авах сүүлчийн өдөр: 2026 оны 12 дугаар сарын 28-ны өдөр

Дараах хэлэлцэх асуудалд ЕРДИЙН ЖУРМААР санал авна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №1: *“Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн дүрэмд өөрчлөлт оруулах тухай*		
Зөвшөөрсөн	**Татгалзсан**	**Түдгэлзсэн**

Дараах хэлэлцэх асуудалд КУМУЛЯТИВ АРГААР санал авна.

ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №2: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн ердийн гишүүдийг нөхөн сонгох				
ЕРДИЙН ГИШҮҮНД НЭР ДЭВШИГЧИД		**Хурлаас гарах шийдвэрийн төсөл**	**Нэр дэвшигчид өгөх саналын тоо**	**Гарын үсэг**
1.		Тогтоол №		
2.				
3.				
4.				
5.				

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг, гарын үсгийн тайлал: _____
/_____/

Огноо: _____

Саналын хуудсыг бүртгэж, хүлээж авсан ажилтны гарын үсэг, гарын үсгийн тайлал:

_____
/_____/

САНАМЖ

1. *Хувьцаа эзэмшигч Та 2026 оны 11 дүгээр сарын 16-ны өдрөөс эхлэн 2026 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 16:00 цаг хүртэл хугацаанд 2026 оны 12 дугаар сарын 01-ний бүртгэлийн өдрөөр эзэмшиж буй хувьцааны тоогоор санал өгөх боломжтой.*

2. *Та саналын хуудсыг бөглөхдөө дараах зүйлийг анхаарна уу.*
   - *Саналыг **ердийн журмаар** өгөх тохиолдолд:*
     - *Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ( ) тэмдэглэгээг хийнэ үү.*
   - *Саналыг **кумулятив аргаар** өгөх тохиолдолд:*
     - *Та өөрийн нийт саналын эрхийг (Нийт саналын эрх = Таны эзэмшиж буй хувьцааны тоо × Сонгогдох ТУЗ-ийн гишүүдийн тоо) нэг нэр дэвшигчид бүгдийг нь өгөх, эсвэл хэд хэдэн нэр дэвшигчид хуваан байршуулах замаар саналаа өгөх эрхтэй.*

3. *Та саналаа өгөхдөө дараах хэлбэрээр өгөх боломжтой. Үүнд:*
   - *"Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн цахим хуудас /www.mse.mn/-аар дамжуулан саналаа цахимаар өгөх;*
   - *Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Д.Сүхбаатарын талбай-3 хаягт байрлах "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн байрны 1-р давхарт биеэр ирж саналаа өгөх;*
   - *өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компаниар дамжуулан саналаа өгөх;*
   - *shareholders@mse.mn хаягаар саналын хуудсыг илгээх.*

4. *Та "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн байранд биеэр ирж санал өгөх, өөрийн үнэт цаасны компаниар дамжуулан санал өгөх, саналын хуудсаа shareholders@mse.mn хаягаар илгээн санал өгөх тохиолдолд дараах зүйлийг анхаарна уу. Үүнд:*
   - *Хувьцаа эзэмшигч хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулан, иргэний үнэмлэхний хуулбарыг хавсаргах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулан, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг хавсаргана.*
   - *Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэн санал өгч байгаа бол төлөөлөх хүндээ итгэмжлэл бичиж өгч нотариатаар баталгаажуулж, итгэмжлэлийн хамт хүчинтэйд тооцно.*
   - *Засварласан, балласан, залруулгатай саналын хуудас нь хүчингүйд тооцогдоно.*

5. *Хэлэлцэх асуудалтай холбогдох асуулт, санал байгаа тохиолдолд дор бичиж өгнө үү.*

Энэ хэсгийг хувьцаа эзэмшигчдийн хурлын тооллогын комисс бөглөнө.

Саналын хуудсыг хүчинтэйд тооцох эсэх: Хэлэлцэх асуудал №1 Тийм/Үгүй
Хэлэлцэх асуудал №2 Тийм/Үгүй

Тооллогын комиссын даргын гарын үсэг, гарын үсгийн тайлал:
_____/_____/

Саналын хуудсыг хүчингүйд тооцсон бол түүний шалтгаан:
_____
_____

Хувьцаа эзэмшигчийн асуулт, санал:
_____
_____
_____
_____
_____
_____
_____
_____

--o0o--

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 48 дугаар
тогтоолын Тавдугаар хавсралт

ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ
КОМИСС

Комиссын дарга:	Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анар
Комиссын гишүүд:	Хяналт, зохицуулалтын газрын захирал А.Мөнхбаясгалан
	Бизнес хөгжлийн газрын захирал Т.Хаш-Эрдэнэ
	Захиргаа, санхүүгийн газрын захирал Х.Эрдэнэбүрэн
	Үйл ажиллагааны газрын захирал И.Жавхлан
Комиссын нарийн бичгийн дарга:	Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга Ж.Золбаяр

--o0o--

Төлөөлөн удирдах зөвлөлийн
2026 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн 48 дугаар
тогтоолын 3үргаадугаар хавсралт

ЭЧНЭЭ САНАЛ ХУРААЛТЫН ТООЛЛОГЫН КОМИСС

Комиссын дарга:	Б.Онон (“БиДиСек ҮЦК” ХК-ийн Институционал харилцагчийн албаны захирал)
Комиссын гишүүд:	Э.Пүрэвжаргал (“БиДиСек ҮЦК” ХК-ийн Институционал харилцагчийн албаны ахлах мэргэжилтэн)
	Г.Анхбаяр (“БиДиСек ҮЦК” ХК-ийн Институционал харилцагчийн албаны мэргэжилтэн)

--o0o--

MONGOLIAN STOCK EXCHANGE

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 11 сарын 06 өдөр Дугаар 49 Улаанбаатар хот

Гишүүнээр элсүүлэх тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.20 дахь заалт, “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Гишүүнчлэлийн журам”-ын 3 дугаар зүйлийн 3.5 дах хэсэг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мот капитал ҮЦК” ХХК-ийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн үнэт цаасны арилжааны гишүүн брокероор элсүүлсүгэй.

2. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн “Гишүүнчлэлийн журам”-ын дагуу “Мот капитал ҮЦК” ХХК-тай “Гишүүнчлэлийн гэрээ” байгуулахыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анарт даалгасугай.

3. Үнэт цаасны зах зээлд мөрдөгдөж буй хууль, тогтоомж, дүрэм, журам, зааврыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллахыг “Мот капитал ҮЦК” ХХК (Ц.Энхмөнх)-д үүрэг болгосугай.

4. Хууль тогтоомж болон зах зээлд мөрдөгдөж буй журам, заавар, “Гишүүнчлэлийн гэрээ”-ээр хүлээсэн гишүүн компанийн үүргийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Анарт үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ш.БАТ-ЭРДЭНЭ

Монголын Хөрөнгийн Бирж ХА 0163 ТУЗ

1508010151

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 11 сарын 06 өдөр Дугаар 50 Улаанбаатар хот

Үүрэгт ажлаас чөлөөлж, албан тушаалд томилох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн "Биржийн дэргэдэх маргаан таслах зөвлөлийн ажиллах журам"-ын 2 дугаар зүйлийн 2.7 хэсэг, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.7.27 дахь заалт, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Биржийн дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга Ц.Шатарын 2026 оны 10 дугаар сарын 16-ны өдөр гаргасан хүсэлтийн дагуу 2026 оны 11 дүгээр сарын 06-ны өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.
2. Дагва овогтой Өлзийбатыг 2026 оны 11 дүгээр сарын 06-ны өдрөөс эхлэн Биржийн дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн даргаар томилсугай.
3. Хууль тогтоомж болон холбогдох журмын дагуу баримт бичиг, тамга тэмдэг, бусад эд зүйлсийг 2026 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн дотор ажил хүлээлцэх акт үйлдэн, баталгаажуулж, хүлээлцэхийг Д.Өлзийбатад даалгасугай.
4. Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам болон Биржийн дэргэдэх Маргаан таслах зөвлөлийн ажиллах журмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж, мэргэжлийн өндөр түвшинд ажиллахыг шинээр томилогдож буй Маргаан таслах зөвлөлийн нарийн бичгийн дарга Д.Өлзийбатад даалгасугай.
5. Д.Өлзийбатад хуралд оролцсон ирцийг үндэслэн түүний үндсэн цалингийн 15 хувиар нэмэгдэл хөлс тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч Д.Нарангэрэлд зөвшөөрсүгэй.
6. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Аудитын хороо (Ж.Золзаяа)-нд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ш.БАТ-ЭРДЭНЭ

Монголын Хөрөнгийн Бирж ХХК 0163 ТУЗ

1502010154

MONGOLIAN
STOCK EXCHANGE

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 11 сарын 06 өдөр Дугаар 57 Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг
түр орлон гүйцэтгэгчийг томилох тухай

Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.5 дахь хэсэг, "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Дүрмийн 5.6, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Б.Болормаагийн 2026 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр гаргасан хүсэлт, "Санал хүргүүлэх тухай" Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын 2026 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн ХЭГ/3650 тоот албан бичиг, Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн хурлын дэлгэрэнгүй тэмдэглэлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Б.Болормаагийн 2026 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр гаргасан өөрийн хүсэлтээр чөлөөлөгдөх хүсэлтийг харгалзан "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох, нөхөн сонгуулиар Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн сонгогдох хүртэл хугацаанд Б.Батцэцэгийг Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүргийг түр орлон гүйцэтгүүлэхээр томилсугай.

2. Б.Батцэцэгт Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний үүргийг түр орлон гүйцэтгэх хугацаанд Төлөөлөн удирдах зөвлөлийн үндсэн гишүүний цалин, урамшууллыг нэгэн адил тооцож олгохыг Ерөнхий нягтлан бодогч Д.Нарангэрэлд зөвшөөрсүгэй.

3. Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хороо (Ж.Золзаяа)-нд даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА Ш.БАТ-ЭРДЭНЭ

Монголын Хөрөнгийн Бирж
ХХА 0163
ТУЗ

1526010146